



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 424

Улаанбаатар хот

“Найманжандаг” хадгаламж, зээлийн хоршооны  
тусгай зөвшөөрлийг сунгах тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журмын 9.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Найманжандаг” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд холбогдох тэмдэглэгээг 2016 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хийлгэхийг “Найманжандаг” ХЗХ /Д.Оюунчимэг/-нд үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, холбогдох өөрчлөлтийг Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДЭД ДАРГА



О.БАТБОЛД